



ЗАХИРАЛ **20240511** Н.ЭНХБАТ
9098429 А ХНТ8637

“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ЦАХИМ СИСТЕМД СУУРИЛСАН АНГЛИ ХЭЛНИЙ ХӨТӨЛБӨР” НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго:

Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний хөтөлбөрийн хэрэгжилт, чанарыг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн англи хэлний хөтөлбөр нэвтрүүлэх, цахим систем нэвтрүүлэх, багш нарыг чадавхжуулахад оршино.

Төсөл үргэлжлэх хугацаа: 2023-2024 оны хичээлийн жил

Захиалагч байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 33 дугаар сургууль

Үндэслэл

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" болон "Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)"-нд хүүхэд, залуучуудад олон улсад мэдлэг, ур чадвараараа өрсөлдөх, ерөнхий боловсролын сургуульд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх, их, дээд сургуулийн олон улсад эзлэх эрэмбийг ахиулахад дэмжлэг үзүүлэх, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, чадвартай иргэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагыг хөгжүүлэхэд англи хэлний суралцахуйг бүх түвшинд дэмжихэд тусгасан.

Тиймээс улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварын нэгэн чухал хэмжүүр болсон англи хэлийг чөлөөтэй эзэмших боломжийг нээх, технологийн ололт дэвшлийг сургалтын үйл ажиллагаанд чадварлаг ашиглах, сурагчдын мэдлэг, чадвар, хандлагад гарах үр дүнд баримжаалан сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлдэг бусадтай хамтран насан туршдаа суралцаж чаддаг байх нь нэн чухал байна.

Олон улсын стандартад нийцсэн цогц хөтөлбөрийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах, сургалтын үйл ажиллагааг технологийн дэвшилтэт цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх, сурагчдын англи хэлний мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, ахиц, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, багш нарын англи хэлний мэдлэгийн түвшин, ур чадварыг сайжруулах шаардлагатай байна.

Улмаар Монгол улсын засгийн газрын 2021 оны 372 дугаар тогтоолоор баталсан "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ"-ний 4.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны А/353, А/461 дүгээр тушаалаар олон улсын жишигт нийцсэн цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулиудад үе шаттай нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

Хамрах хүрээ:

Захиалагч

Гүйцэтгэгч

- Ерөнхий боловсролын сургуулийн 5, 6 дугаар ангийн 745 сурагч

Хүлээгдэж буй үр дүн

- Монгол Улсын сургалтын хөтөлбөртэй нийцсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцсэн англи хэлний цогц хөтөлбөртэй болсон байна.
- Англи хэлний хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн явц, үр дүнтэй холбоотой мэдээллийг цахим технологи ашиглан богино хугацаанд цуглуулах, багшийн ажлын ачааллыг бууруулах, арга зүйгээ төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх цогц цахим систем бий болсон байна.
- Хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнг хянах эрх нээгдсэн байна.
- Англи хэлний мэдлэг, ур чадварыг үнэлэх үнэлгээний цогц системтэй болсноор багш тест боловсруулах, хэвлэх, гараар засах ачааллыг шийдсэн байна.
- Монгол үндэсний соёл, ахуй багтсан цаасан болон цахим интерактив сурах бичиг, дасгал ажлын номтой болсон байна.
- Суралцахуйн үр дүнг хянах үйлийг технологи ашиглан шийдвэрлэснээр богино хугацаанд дэмжлэг үзүүлэн алдааг залруулж, сурлагын хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлэн, багшийн ажлын ачааллыг багасгах боломж бүрдсэн байна.
- Хүүхдийн сонирхол, хэрэгцээ, англи хэлний сургалтын хөтөлбөрийн 5, 6 дугаар анги, туршилтын 38 сургуулийн 7-10 дугаар ангийн агуулгатай уялдсан дасгал, даалгаврын сан бүрдсэн байна.
- Ерөнхий боловсролын сургуулиудын 5-6 дугаар анги, туршилтын 38 сургуулийн 7-10 дугаар ангийн суралцагчдын англи хэлний мэдлэг, чадварын түвшин 2 ба түүнээс дээш хувиар ахисан байна.

Тавигдах шаардлага:

1. Хөтөлбөр, сурах бичиг, багшийн гарын авлагад тавигдах ерөнхий шаардлага:
 - Олон улсын стандартад нийцсэн англи хэлний хөтөлбөрийг үндэсний агуулгатай хослуулан боловсруулж, байршуулах
 - Хэлний үндсэн чадвар болон ирээдүйн ур чадварыг багтаасан суралцахуйн зорилт, нэгж, ээлжит хичээлийн жишиг төлөвлөгөө Монгол болон Англи хэл дээр байршсан байх
 - Зайнаас заах аргачлал бүхий арга зүйн зөвлөмж байршсан байх
 - Үнэлгээний бүх төстийн санг байршуулсан байна. Үүнд, Оношлох, бүлэг сэдэв бүрийн тест буюу явцын тест, ур чадварын тест, хэлний хэрэглээний тест, үгийн сангийн тест, дүрмийн тест байх
 - Цахим сурах бичиг нь туршигдсан байх
 - Цахим сурах бичиг нь ерөнхий боловсролын сургуулийн 5-11 дүгээр ангийн сурагчдын насны онцлогт тохирсон агуулгатай, олон улсын стандартад нийцсэн байх
 - Хөтөлбөр хэрэгжих бүх ангийн цахим сурах бичиг, цахим дасгал ажлын ном цахим системд байршсан байх

- Хөтөлбөр хэрэгжих бүх ангийн багшийн ном, гарын авлага Монгол болон Англи хэл дээр цахим системд байршсан байх
- Бүх ангийн сурах бичиг, дасгал ажлын номын хариу, интерактив дасгал ажлууд, сонсох дасгалын аудио, видео байршсан байх
- Цахим системээр дамжуулан үзсэн агуулгаар явцын үнэлгээ, бүлгийн үнэлгээ, ур чадварын үнэлгээг хийдэг байх
- Цахим сурах бичгээ ашиглан багш хичээл заах боломжтой байх
- Цахим платформд ажиллах алхамчлал хүүхдэд хялбар байх
- Сурагчид өөрсдөө бие даан хичээлээ судлах боломжтой байх
- Дасгал, даалгаврын үнэлгээг шууд харах боломжтой байх
- Дүрмийн хичээлийг бүлэг бүрт тохируулан бэлдэж байршуулсан байх
- Англи хэлний олон улсын шалгалтуудтай хөтөлбөрийн агуулга хэрхэн нийцэж байгаа нийцлийн тайлбар, олон улсын шалгалтанд бэлтгэх зөвлөмж байршсан байх
- Цахим сургалтын платформ ашиглах бүрэн гарын авлага заавар байршсан байх
- Суралцагчдын идэвх оролцоо, суралцахуйг дэмжсэн, үргэлжлүүлэн судлах сэдлийг төрүүлэхүйц амьдралтай холбон цаашид ашиглахуйц байх
- Даалгаврын гүйцэтгэлийн мэдээлэл нь багш, суралцагчдад асуудлаа тодорхойлох, үр дүнг сайжруулахад дэмжлэг болохоор байх

2. Платформын бүтцэд тавигдах шаардлага:

- Цахим систем нь олон улсад тавигддаг нийтлэг шалгуур, шаардлагыг хангасан байх;
- Бүртгэлийн болон нэвтрэх хэсэгтэй байх
- Цахим анги, бүлэг үүсгэх боломжтой байх
- Даалгавар өгөх, шалгалт авах цэстэй байх. Сурагчдын үнэлгээний шалгалтуудыг зохиох, авах болон тайлагнах нөхцөл бүрдсэн байна.
- Онлайн хичээл явуулах, ялгаатай түвшинд тохируулан бүлэг үүсгэх, тохирсон дасгал даалгаврыг сангаас өгөх, шууд үнэлэх системтэй байх
- Цаг ашиглалтыг хянах боломжтой байх
- Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнг хянах хэсэг: сурагч, анги, бүлэг, сургууль, дүүрэг, аймаг, үндэсний түвшин тус бүрээр сонгож үр дүнг хянах боломжтой байх
- Багшид зөвлөмж хэсэгтэй байх
- Шаардлагатай тохиолдолд дэмжлэг авах, холбогдох тусламжийн хэсэгтэй байна

3. Системийн үзүүлэлт.

- Windows үйлдлийн системийн 10 ба түүнээс хойш хувилбар, Mac үйлдлийн системийн 11 ба түүнээс хойш хувилбар, Linux үйлдлийн системийн Ubuntu 12.04 ба түүнээс хойш хувилбар, Fedora 218 Debian 8 үйлдлийн системд ашиглах боломжтой байх
- Ухаалаг утасны Android 9 түүнээс хойш хувилбар, iOS 15 түүнээс хойш хувилбар дээр ашиглах боломжтой байх

- Тухайн системийг ашиглахтай холбоотой үүссэн өгөгдлийн эзэмшигч нь ерөнхий боловсролын сургууль байна.

Жич: Онцгой эрхийн гэрчилгээ эсвэл олон улсын хөтөлбөр ашиглах гэрээ байгуулсан байх шаардлагатай.

.....
Захиалагч

.....
Гүйцэтгэгч